



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

### 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн XV дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварт цар тахалын улмаас үүссэн нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны мн/250 дугаар тогтоолд заасны дагуу 05 дугаар сарын 01-ний өдрөөс 15-ны өдрүүдэд хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулалтын өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. Үүнд:

1.1. Нийслэл Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорноговь, Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх;

1.2. Зэвсэгт хүчний 032 дугаар анги хилийн ангиудаас бусад цэргийн нэгтгэл, ангид хугацаат цэргийн алба хаагч татахгүй байх;

1.3. Улаанбаатар цэргийн хүрээний хилийн ба дотоодын цэргийн ангиудад хугацаат цэргийн алба хаагч хуваарилахгүй байх;

1.4. Цэрэг татлагын үйл ажиллагааг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар болон аймгуудын Засаг даргын Тамгын газар богино хугацаанд үр дүнтэй, өндөр түвшинд зохион байгуулж явуулах;

1.5. Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тооны дагуу аймаг, орон нутагт байрлах хилийн цэргийн ангиудад тухайн аймаг, зэргэлдээх аймгуудаас хугацаат цэргийн алба хаагчийг татах ажлыг хэрэгжүүлэх;

1.6. Аймгийн Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллахдаа нарийвчилсан график төлөвлөгөө гаргаж, нэг дор 5-аас дээш цэрэгт татагдагч иргэн цуглуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах;

1.7. Аймаг, орон нутаг дахь цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөж ажиллах;

1.8. 2020 онд “Оюутан-цэрэг” сургалтыг зохион байгуулахгүй байх;

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж хугацаат цэргийн албанд иргэдийг татах ажлын талаарх мэдээллийг тогтмол ирүүлж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт тус тус даалгасугай;

3. Энэ тогтоолыг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

ДАРГА,  
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

A large, stylized handwritten signature in black ink, corresponding to the name G. Ariunbuyan.